

“Хавдар судлалын тулгамдсан асуудал-2023” эрдэм шинжилгээний хурлын тайлан

2023.10.14-15

Улаанбаатар

Дэлхий дахинаа жил бүр 8 сая гаруй хүний амьдралыг авч одож буй хорт хавдар өвчнөөс сэргийлэх, эмчлэх, хянах асуудалд дэлхий нийтээрээ ихээхэн анхаарч, энэ аюулт өвчинтэй тэмцэх үйлсэд эмч, мэргэжилтнүүд төдийгүй төр засаг, хувь хүн, хамт олон, олон улсын байгууллага болон хувийн хэвшлийнхэн хамтран ажиллаж байна.

Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ) нь 2009 оноос эхлэн “Хавдар судлалын тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын симпозиум, эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж ирсэн. Энэ жилийн хурлыг Сетунари ХХК, Новартис ХХК, Монос трейд ХХК, Монголын хавдар судлаач эмч нарын нийгэмлэг болон УИХ-ын гишүүн Ж.Чинбүрэнгийн ажлын албатай хамтран, 2023 оны 10 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд Новотел зочид буудалд зохион байгууллаа.



Новотел зочид буудал
2023.10.14-15

Эрдэм шинжилгээний хурлыг ХСҮТ-ийн ерөнхий захирал, АУ-ны доктор, дэд профессор Н.Эрдэнэхүү болон Улсын их хурлын гишүүн, АУ-ны доктор Ж.Чинбүрэн, ЭМЯ-ны Эмнэлгийн тусламж үйлчилгээний газрын дарга Д.Баярболд нар нээж, ЭМЯ-ны Лавлагаа шатлалын тусламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Тэмүүлээ, Монос трейд ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Цэрэнбат нар уригдан оролцлоо. Тус хуралд гадаад, дотоодын олон төлөөлөл уригдан ирж, оролцсоны дотор ОХУ-ын ЭМЯ-ны хавдрын ерөнхий мэргэжилтэн, ОХУ-ын Хавдар судлаачдын нийгэмлэгийн ерөнхийлөгч, шинжлэх ухааны доктор, профессор Каприн Андрей Дмитриевич цахим мэндчилгээ илгээж, Япон улсын Хирошимагийн ИС-ийн профессор Нагата Ясуши, Хавдрын Осака төвийн профессор Toshinori Ito, Анагаахын лабораторийн хүрээлэнгийн Профессор Jun Takanari, Тайваний Үндэсний ИС-ийн профессор Мин Чи Хо, профессор Ming Chih Ho нар сонирхолтой илтгэл тавьлаа.

Энэ жилийн эрдэм шинжилгээний бага хурлыг дараах үндсэн болон салбар хуралдаанаар зохион байгууллаа. Үүнд:

Салбар хуралдааныг "Хавдрын хими, бай эмчилгээ", "Хавдрын ангиографийн эмчилгээ", "Монгол улс дахь хүний папиллома вирусийн шалтгаани умайн хүзүүний хорт хавдрын оношилгоо, эмчилгээний менежмент" сэдвээр 2023 оны 10 дугаар сарын 14-ны өдөр Новотел зочид буудлын Ballroomд зохион байгуулж, 18 илтгэлийг хэлэлцүүлжээ.

Үндсэн хуралдааныг “Хавдар судлалын тулгамдсан асуудлууд” сэдвийн дор 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдөр “NOVOTEL” зочид буудлын Ballroom-д тус тус зохион байгуулж, улс болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 320 эмч мэргэжилтнүүд (давхардсан тоогоор) хамрагдлаа. Ялангуяа 21 аймаг, 9 дүүргийн хавдар судлаач эмч, эмэгтэйчүүдийн эмч нарыг урьж оролцуулсан нь онцлог байлаа. Энэ удаагийн үндсэн хуралдааныг “Хорт хавдрын салбарын хөгжлийн чиг хандлага”, “Монгол улсын хавдар судлалын салбарын судалгаа, шинжилгээний ажлын үр дүн” гэсэн 2 хэсэгтэйгээр зохион байгуулж, зочин илтгэгчдийн 5 илтгэл, эмнэл зүйн судалгааны 9 илтгэлийг хэлэлцүүлээ.



Тус хуралд судалгаа, шинжилгээний нийт 27 бүтээл, эмнэл зүйн тохиолдлын 20 танилцуулга, лекц тойм 2, шинэ технологи 3, ханын 8 илтгэл ирүүлснээс хуралдааны явцад 5 судлаач, эмч нарын судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлж, шилдэг илтгэлийг шалгаруулж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа.

Аман илтгэлийн төрлөөр:

- I-р байр “Мэс заслын дараах улаан хоолойн залгалт тавигдсан хүндрэлд уян дурангаар вакум үүсгэж эмчлэх эмчилгээний үр дүн” сэдвээр ХСҮТ-ийн Дурангийн тасгийн эмч Б.Амарбат,
- II-р байр “Хүний папиллома вирусын халдварыг илрүүлэх шинжилгээний сорьцыг эмэгтэй өөрөө өөрөөсөө авах аргын туршилт судалгаа” сэдвээр ХСҮТ-ийн Бүртгэл тандалт, эрт илрүүлгийн албаны эпидемиологич эмч Ж.Уранболор,

- III-р байр “Гепатитын С вирусийн эмчилгээний дараа тогтвортой хариу урвал илэрсэн (SVR) эмчлүүлэгчийн элэгний эст өмөнгөөр өвчлөх эрсдлийн судалгаа: Говьсүмбэр аймаг 2017-2022 он” сэдвээр ХСҮТ-ийн Элэг шилжүүлэн суулгах албаны Гепатологич эмч Ч.Мөнхзаяа,
Ханын илтгэлийн төрлөөр “Эрчимт эмчилгээний тасагт хөдөлгөөнд эрт оруулсан үр дүн” сэдвээр ХСҮТ-ийн Сэргээн засах, тусламж үйлчилгээний тасгийн Хөдөлгөөн засалч Б.Батчимэг нар шалгарлаа.



ХСҮТ-ээс жил тутам эрхлэн гаргадаг “Хавдар судлал” эрдэм шинжилгээний сэтгүүлд 52 гаруй судлаач, эмч нарын нарын бүтээлийн эмхэтгэл хэвлэгдэж, 300 ширхгийг эмч, мэргэжилтэн, судлаачдад түгээлээ.



Хуралдааны үеэр МҮОНРТ, UBS, C1, TV9, TV5, ТВ8, ETV, Eagle, Монгол HD, TV 25, МҮРадио, Монголын радио болон Өдрийн мэдээ, Зууны мэдээ зэрэг 14 орчим хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх ярилцлага, мэдээ мэдээллийг хүн амд хүргэлээ.

Хянасан:

Тайлан бичсэн:

Ц.Бадамсүрэн /ХСҮТ-ийн НЭМТСА-ны дарга/
Д.Алтанзаяа /ХСҮТ-ийн ЭШХХ мэргэжилтэн/